БАТЛАВ:
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГА Б.АМГАЛАНБАТ

1825020026 9073955

ХЭНТИЙ АЙМГИЙН ХЭРЛЭН СУМАНД ХЭРЛЭН ГОЛЫН
ТАТАМ ДАГУУ “ХАМГААЛАЛТЫН ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ” АЖЛЫН
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Үндэслэл	Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2021 оны 58 дугаар зарлиг, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Гучин сая мод” хөтөлбөр, төлөвлөгөө, аймгийн 2025 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн 10 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
Захиалагч байгууллага	Хэнтий аймгийн Байгаль орчны газар
Хамгаалалтын ойн зурвас байгуулах газрын байршил	Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт Хэрлэн голын татамын дагуу 1.5 га талбайд хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг зохиог байгуулна. /Байршлын зураглалыг хавсаргав/
Бэлтгэл үе шат	• Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэх улирлын болон түр ажилчдыг сургаж, дадлагажуулах; • Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажилд хэрэглэх техник, тоног төхөөрөмжийг бэлэн болгох; • Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын технологийн карт, технологийн дараалал боловсруулах; • Хамгаалалтын ойн зурвас байгуулах талбайг сонгож тэмдэгжүүлэх • Улирлын болон түр ажилчдад ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэн өгөх; • Ажил гүйцэтгэгч, захиалагч, гүйцэтгэх хугацаа, талбайн хэмжээ, тарьсан модны модны тоо, схем зэрэг мэдээлэл агуулсан самбар байрлуулах;
	• Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын норматив зардлын хүрээнд сонгосон талбайд хашаа барих; • Хашааны шон газрын гадаргаас дээш 1,5 метр өндөртэй, шон хоорондын зай 2,5 метр, урт 150 м, өргөн 100 м хэмжээтэй нийт урт 500 м хашааг барих: Үүнд: • Кординатын цэг: 1.47°16'48.21"N 110°36'13.17"E 2.47°16'50.40"N 110°36'19.54"E 3.47°16'45.34"N 110°36'15.32"E 4.47°16'47.58"N 110°36'21.67"E • Хашааны шонгийн урт 2 м, гурван тийш салаа бүхий, газарт цохиж суулгах зориулалтын төмөр хийцтэй байх бөгөөд шонг 0.5 м гүнд суулгах • Хашааны тор 1,2 м өндөртэй, нүхний хэмжээ нь 10*10 см-ээс

Хамгаалалтын ойн зурвас байгуулах	• Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын норматив зардлын хүрээнд сонгосон талбайд хашаа барих; • Хашааны шон газрын гадаргаас дээш 1,5 метр өндөртэй, шон хоорондын зай 2,5 метр, урт 150 м, өргөн 100 м хэмжээтэй нийт урт 500 м хашааг барих: Үүнд: • Кординатын цэг: 1.47°16'48.21"N 110°36'13.17"E 2.47°16'50.40"N 110°36'19.54"E 3.47°16'45.34"N 110°36'15.32"E 4.47°16'47.58"N 110°36'21.67"E • Хашааны шонгийн урт 2 м, гурван тийш салаа бүхий, газарт цохиж суулгах зориулалтын төмөр хийцтэй байх бөгөөд шонг 0.5 м гүнд суулгах • Хашааны тор 1,2 м өндөртэй, нүхний хэмжээ нь 10*10 см-ээс ихгүй хэмжээний нүхтэй, 3 мм-ийн зузаан сүлжмэл төмөр торыг хашааны төмөр шонтой бэхэлсэн байх; • Хашаанд 2 давхар эрчлээтэй өргөстэй төмөр торыг шонгийн дээд, дунд, доод хэсгээр торны гадуур 3 үе татаж бэхлэх • Ойн зурвасыг урт 150 м, өргөн 100 м хэмжээтэй нийт 500 м урттай хашаа барьж, нийт 1.5 га талбайг хашаална. • Газрын налуу болон жалгын ховилоор хашаан доогуур мэрэгч амьтан болон мал орохоос хамгаалсан хамгаалалттай байх; • Усны эх үүсвэр, газрын налууг харгалзан явган хүн орох, усалгааны авто машин орох, гарцыг гаргах. • Хашаанд орох гарцын хажууд мэдээлэл бүхий 40*60 харьцаатай самбар хөдөлгөөнгүй байршуулна. */Талбайн хэмжээ, мод тарьсан схем, тарьсан модны тоо, төрөл, захиалагч, гүйцэтгэгч тодорхой бичнэ.* • “Навчит төрлийн модны суулгац. Техникийн шаардлага” MNS 6141:2010 стандартыг мөрдөх бөгөөд 1 дүгээр зэргийн суулгацуудыг ойн зурвас байгуулах ажилд хэрэглэх; • “Суулгацын нүхийг бэлтгэх, суулгах арга. Ерөнхий шаардлага” MNS 6258-1:2011 стандартын дагуу суулгацын нүхийг бэлтгэх; • Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг 5-р сарын 20-ноос 10 -р сарын 20 хүртэл хийж хүлээлгэж өгнө. **Нийт талбайд 1200 ширхэг мод тарина. Үүнд:** **Бургас: Тоо хэмжээ -1200 ш** **Өндөр: 1 м-ээс доошгүй** - **Схем – Хашаанаас 2 метрийн зайтай, эгнээ хооронд 3 м, Ургамал хооронд 2,5 м нүх ухаж тарина.** - **Модны нүхийг 40-50 см ухаж бэлтгэн, нүхний 3/1-хэмжээнд малын хөх бууц хийж хөрсийг бэлтгэнэ.** • Тарьсан суулгацыг 2025 оны 5-10 сарын хугацаанд усалгаа арчилгаа хийж, гадны хүчин зүйлээс хамгаална
	Хамгаалалтын ойн зурвас байгуулсан талбайг 2025 оны 10 сарын 30 –ны өдрөөс өмнө Аймгийн Байгаль орчны газраас томилогдсон ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулна. Хамгаалалтын ойн зурвас байгуулсан талбайг Дархан сумын Засаг даргын тамгын газарт акт үйлдэн хүлээлгэн өгнө. Актыг 4 хувь үйлдэнэ. Амьдралтын хувийг тогтоохдоо Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А-96/71 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

<table>
<tr><td>Талбайг хүлээлгэн өгөх</td><td>“Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу жишиг талбай байгуулан тооллого явуулна.

<table><tr><td>Хамгаалалтын ойн зурвасын талбай /га/</td><td>Жишиг талбайн нийлбэрийн ойжуулсан талбайд эзлэх хувь</td><td>Нэгж жишиг талбайн хэмжээ /м2 /</td></tr><tr><td>1-5</td><td>5</td><td>200</td></tr><tr><td>6-10</td><td>4</td><td>400</td></tr><tr><td>11-20</td><td>3</td><td>400</td></tr><tr><td></td><td>2</td><td>400</td></tr></table>
Хамгаалалтын ойн зурвас байгуулсан ажлыг гэрээний ерөнхий ба тусгай нөхцөлийн дагуу зөрчил, гологдлыг арилгасны дараа “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмаар батлагдсан актын дагуу хүлээн авна.</td></tr>
<tr><td>Зөрчил, гологдол арилгах</td><td>• 50-74.9 хувийн амьдралттай ургасан бол гүйцэтгэгч өөрийн зардлаар 100 хувь нөхөн тарилт хийж, актаар хүлээлгэн өгнө.
• 25-49.9 хувийн амьдралтай ургасан бол гүйцэтгэгчид гүйцэтгэлээр олгосон норматив зардалд хүрэхүйц шаардлагатай нөхөн тарилтыг гүйцэтгэгчийн хөрөнгөөр хийлгэж дараа жилийн намар хүлээж авна.
• 25.0 хүртэл хувийн амьдралтай тоологдсон тохиолдолд уг ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн гэж үзэж гүйцэтгэгчээр ойн зурвасын ажлын гүйцэтгэлээр олгогдсон төлбөрийг эргүүлэн төлүүлнэ</td></tr>
<tr><td>Тайлан боловсруулах</td><td>• Тайлан дор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:
а/ “Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэсэн тайлан”;
б/ “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймгийн Байгаль орчны газрын даргын ажлын хэсэг байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт.
• Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил гүйцэтгэсэн тайланд:
а. Хамгаалалтын ойн зурвас байгуулсан ажлын үе шат тус бүрээр хийсэн ажлын гүйцэтгэл, ажлын технологийн дараалал, тарилтын схем, тарьц, суулгацын стандартын шаардлага хангасан байдал, гарал үүсэл, ажил гүйцэтгэсэн хугацаа, ажиллах хүчин, ажлын өдөр тутмын гүйцэтгэл, тавьсан хяналт зэрэг мэдээллийг багтаана. Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, ойн зурвасын ерөнхий байдлын зураг, эхлэл төгсгөлийн зургийг харьцуулсан байдлаар фото хэлбэрээр тайланд хавсаргана.
б. Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил явуулсан талбайн зурагт талбайн хилийн солбицол, дугаар, талбайн хэмжээ, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлол, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.
в. “Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх” журмын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын ажил хүлээн авах ажлын хэсэг</td></tr>
</table>

	байгуулсан шийдвэрийн хуулбар, ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгсөн актын хамт тайланд хавсаргана. • Тайланг аймгийн Байгаль орчны газрын ажил хүлээн авах ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайлангийн боловсруулалт шаардлага хангахгүй бол түүнийг сайжруулах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ. Тайланг сайжруулсан талаар төслийн менежер мэдэгдэл гарган дахин ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно. • Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (Universal transvers mercator) тусгагийг хэрэглэнэ. Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр 1 хувь ирүүлнэ.
Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх	Хамгаалалтын ойн зурвас байгуулсан ажлын тайланг аймгийн Байгаль орчны газар-т 2 хувийг хүргүүлнэ
Мэргэшсэн инженер техникийн ажилчдын хангамжид тавигдах шаардлага	• Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулахад мэргэшсэн инженер техникийн болон улирлын ажилтнууд нь доорх шаардлагуудыг хангасан байна. • Үүнд: Инженер техникийн ажилтан нь хамгаалалтын ойн зурвас байгуулах ажил буюу гэрээгээр заасан ажилтай ижил төрлийн ажил гүйцэтгэсэн туршлагатай байх, ойн инженер, ой судлаач, ой зүйч, ойн техникч, ойжуулагч, агрономич мэргэжилтэй хүн байна. • Хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг зохион байгуулахад бусад шаардлагатай ажилчидтай /талбайн туслах ажилчид, тогооч, жолооч гэх мэт/ байх;
Гүйцэтгэгч байгууллагад тавигдах шаардлага	• Ойн мэргэжлийн байгууллагын гэрчилгээтэй байх /мод үржүүлэх, ойжуулах ойг нөхөн сэргээх зөвшөөрөл/ • Ойн зурвас байгуулах, мод тарих болон тухайн ажилтай ижил төстэй ажил гүйцэтгэсэн 2-аас доошгүй туршлагатай байх */Тус хугацаанд 2-аас доошгүй ажил гэрээгээр гүйцэтгэсэн байх, гэрээ акт, гэрээ дүгнэсэн акт/* • Мод тарихад шаардагдах багаж, тоног төхөөрөмжтэй байх */ачааны машин-1, мод нүх ухах тоног төхөөрөмж -3 аас доошгүй/* • Ажил зохион байгуулахад удирдлагаар хангах инженер техникийн ажилтан болон туслах ажилтнуудтай байх */ойн инженер-1, ойжуулагч-1, гэрээт ажилтан 3-аас доошгүй/* • Тухайн аж ахуйн нэгж нь модны суулгацын нөөц бүрдүүлсэн байх • Татварт өргүй • Харилцагч банканд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй • Шүүхэд хариуцагчаар татагдаж байгаагүй байх • Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртөгийн 50 хувиас багагүй байх

Боловсруулсан:

Байгаль орчны газрын Ойн хэлтсийн дарга Э.Батсайхан

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН ОВОО СУМАНД ХЭРЛЭН ГОЛЫН
ТАТАМ ДАГУУ “ХАМГААЛАЛТЫН ОЙН ЗУРВАС БАЙГУУЛАХ” ГАЗРЫН
БАЙРШИЛЫН ЗУРАГ

1.47°16'48.21"N 110°36'13.17"E

2.47°16'50.40"N 110°36'19.54"E

3.47°16'45.34"N 110°36'15.32"E

4.47°16'47.58"N 110°36'21.67"E